



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
САНХҮҮ, АР ТАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Л.СҮХЭЭ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013. 4. 15. № 02/110.-ГАГ/2013/02.

Гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж
ажиллах тухай

Монгол Улсын Ерөнхий Аудиторт УАГ-аас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн "Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн"-гийн аудитаар тус газраас 2012 онд улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгах явцад СХД-ийн цагдаагийн хэлтсийн барилгын өргөтгөлд 379.0 сая төгрөг батлагдсан боловч 30.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарч, бүрэн хэрэгжээгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна. Үүнд:

Тус газрын харьяа СХД-ийн цагдаагийн хэлтсийн барилгын өргөтгөлийн ажлын гүйцэтгэгч "ЭЭН" ХХК нь тайлант онд гэрээгээр гүйцэтгэх ажлаа хийж дуусаагүй байна. Иймд он дамжин баригдаж байгаа барилгын ажлыг дуусгаж 2013 оны 12 дугаар сарын 05-ны дотор Үндэсний аудитын газарт хариу ирүүлэхийг Цагдаагийн Ерөнхий газрын санхүү, ар талын газрын дарга Л.Сүхээ, Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ш.Эрхэмбаяр нарт даалгав.

АХЛАХ АУДИТОР



С.СЭРЧХОРОЛ